Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэбүрэн сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 2 531.8 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 50.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 40.5 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрдэнэбүрэн сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 88.9 сая төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр өмчийн дансдууд байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлан/сая.төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /тоо/	Өөрчлөлт /хувь /
Мөнгөн хөрөнгө	36.2	190.2	-153.9	124%
Авлага	211.3	220.7	-9.3	4.4%
Бараа материал	169.0	179.1	-10.1	5.9%
Үндсэн хөрөнгө	4,327.6	4,252.5	75.0	18.2%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,762.3	4,851.2	-88.9	1.8%
Богино хугацаат өр төлбөр	5.4	27.3	-21.8	106%
Цэвэр хөрөнгө, өмч	4,756.87	4,823.87	-67.	1.4%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,762.3	4,851.2	-88.9	1.8%

Эх сурвалж: Эрдэнэбүрэн сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 36.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 190.3 сая төгрөг болж 75.6 сая төгрөгөөр буюу 47 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 153.9 сая төгрөг нь Төрийн сангийн харилцах дансанд, үлдэх 5.3 сая төгрөг нь арилжааны банкны дансанд 0.07 байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 211.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 220.7 сая төгрөг болж 9.3 сая төгрөг буюу 10 хувиар өссөн байна.

Хүснэгт №02 Авлагын үлдэгдэл /сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	8.9	2.4	6.5
Төлбөртэй үйлчилгээний авлага		27.1	(27.1)
Байгууллагаас авах авлага	14.3	26.8	(13.5)
Хувь хүмүүсээс авах авлага	0.3	0.3	0
Зээлийн хүүгийн авлага	187.7	164.1	23.6
Татвар, НДШ /ОНӨААТҮГ/			
АВЛАГЫН НИЙТ ДҮН	211.4	220.7	(9.3)

Эх сурвалж: Эрдэнэбүрэн сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын үлдэгдэлд 74.3 хувь буюу 164.2 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага, 1.1 хувь буюу 2.4 сая төгрөг нь ажиллагсадтай холбогдсон авлага, 12.1 хувь буюу 26.8 сая төгрөг нь байгууллагаас авах авлага, үлдэх 12.5 хувь 27.4 сая төгрөгийг бусад авлага эзэлж байна.

СХС-гаас бусад 56.6 сая төгрөгийн авлага нь дараа онд барагдах бүрэн боломжтой авлага байна.

СХС-гийн 164.2 сая төгрөгийн авлагын дийлэнхийг сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага эзэлж байгаа бөгөөд оны эхэнд 187.8 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант хугацаанд 12.5 сая төгрөгийн зээл олгож, 43.5 сая төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн төлөгдөж, оны эцэст 164.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Сангаас 2011-2015 онд олгосон 25 зээлдэгчтэй холбоотой 87.7 сая төгрөгийн авлага нь хугацаа хэтэрсэн авлага байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 179.1 сая төгрөг болж 10.1 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал, аж ахуйн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч зарцуулаагүйтэй холбоотой нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 198.7 сая, үнэ төлбөргүйгээр 44.7 сая, нийт 243.4 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж, 233.3 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 5,460.5 сая төгрөг байсан бол оны эцэст 5,604.3 сая төгрөг болж 185.6 сая төгрөгөөр өссөн нь 21.6 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авсан, ОНХС, ХХААГ зэрэг бусад эх үүсвэрүүдээс бий болсон 88.9, Эрүүл мэндийн төвд ирсэн автомашин, мотоцикль, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг 74.3 сая төгрөгийн хандиваар бүртгэсэнтэй холбоотой байна.

Сумын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрээр 0.5 сая төгрөгийн барилга, аймгийн ИТХ-ын шийдвэрээр мал эмнэлгийн машин тусгай зориулалтын автомашин 19.9, соёлын төв, ерөнхий боловсролын сургууль тоног төхөөрөмж 8.6, тавилга эд хогшил 12.6, нийт 41.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 5.4 сая, эцсийн үлдэгдэл 27.3 сая төгрөг болж 21.9 сая төгрөгөөр өссөн байна. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 16.4 сая төгрөгийн өр байгаа нь дараа тайлангийн хугацаанд бүрэн барагдах боломжтой өглөгүүд байна. Өглөгийг нэр төрлөөр авч үзвэл: ажилчидтай холбоотой өглөг 8.0, байгууллагад өгөх өглөг 19.3 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл байна.

3.5.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 4,756.8 сая төгрөг байсан оны эцэст 4,823.8 сая төгрөг тайлант он 3,412.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 67.2 сая төгрөгийн үр дүнтэй, өмнөх үеийн үр дүн рүү 2.8 сая төгрөгөөр залруулсан тус тус нөлөөлсөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,214.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2,214.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Эрдэнэбүрэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03 өдрийн 3/03 тоот тогтоолоор 2,065,8 сая төгрөгөөр анх баталж өмнө оны болон тайлант оны орлого давсан холбоотойгоор 2021 онд 1 удаа тодотгол хийн 2021 оны 08 дугаар сарын 05-ны 4/03 тоот тогтоолоор нийт 2,149.6 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2021 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн 3/03 тоот тогтоолоор 2,149.6 сая төгрөгөөр 6 байгууллага, 2 сангийн төсвийг тодотгож баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 2,149.6 сая төгрөгийн төсөв баталснаас 1,298.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 783.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 26.9 сая төгрөгийг ЭМДС-аас, 69.8 сая төгрөгийг ОХНС-аас санхүүжих, 0.6 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 30.4 сая төгрөгийг туслах үйл ажиллагаанаас, 10.0 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт №3. Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төгрөг/

Нэр төрөл	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
Улсын төсвөөс санхүүжих	1,298.5	1,272.7	25.80
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,298.5	1,272.7	25.80
Орон нутгийн төсвөөс санхүүжих	783.3	783.3	-
Орон нутгийн төсвөөс	713.4	713.4	-
Орон нутгийн хөгжлийн сан	69.9	69.9	-
Нийгмийн даатгалын төсвөөс санхүүжих	26.9	26.6	0.30
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	26.9	26.6	0.30
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	41.0	44.5	(3.5)
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	0.6	1.2	(0.6)
Туслах үйл ажиллагааны орлогоос	30.4	43.3	(12.90)
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	10.0	0	10.0
ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН	2,149.7	2,127.1	22.6

Эх сурвалж: Эрдэнэбүрэн сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1272.7, орон нутгийн төсвөөс 783.3, ОНХС-ийн санхүүжилт 69.9, ЭМДС-аас санхүүжих 26.6, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.2, туслах үйл ажиллагааны орлогоос 43.3 сая, нийт 2127.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2094.5 мянган төгрөгийг зарцуулж 32.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2094.5 сая төгрөг буюу 97.4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 8.1 сая төгрөгөөр, нормативт зардал 19.0, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.6, эргэж төлөгдөх зээлийг 27.3 сая төгрөгөөр буюу нийт 55.1 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6, туслах үйл ажиллагааны орлого 30.4 сая төгрөгөөр тус тус батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 1.2 сая, туслах үйл ажиллагааны орлогыг 43.3 сая төгрөгөөр нийт 44.5 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн. Нийт бүрдүүлсэн орлогын 43.5 сая төгрөгийг СХС-ийн зээл, зээлийн хүүгийн орлого, 1.0 сая төгрөг нь сумын соёлын төвийн өөрийн орлого бүрдсэн байна.

Эрдэнэбүрэн сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн 3/03 дугаар тогтоолд Эрдэнэбүрэн сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 136.7 сая төгрөгийн татварын орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 201.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 47.1 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 4. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төгрөг/

Орлогын ангилал	2021 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	136.7	201.1	(64.4)
Нийт орлого ба тусламжийн дүн	136.7	201.1	(64.4)
Татварын орлого	135.7	200.4	(19.9)
Орлогын албан татвар	15.5	26.7	(11.2)
Хувь хүний орлогын албан татвар	15.5	26.7	(11.2)
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын			-
Үйл ажиллагааны орлого	5.0	22.3	(17.3)
Суутгагчийн бусад орлого	10.5	4.4	6.1
Шууд бус орлого			-
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	-	-
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт			-
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	-	-	-
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар			-
Хөрөнгийн албан татвар	13.1	18.2	(5.1)
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар			-
Бууны албан татвар	2.1	3.0	(0.9)
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	11.0	15.2	(4.2)
Хөрөнгө борлуулсаны албан татвар	-	0.2	(0.2)
Хөрөнгө борлуулсаны албан татвар		0.2	(0.2)
Бусад татвар, телбер, хураамж	29.1	32.5	(3.4)
Бусад нийтлэг телбер, хураамж			-
Улсын тэмдэгтийн хураамж	2.4	28.4	(26.0)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	8.7	1.8	6.9
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	18.0	2.3	15.7
Газрын телбер	0.1	0.1	(0.0)
Газрын телбер	0.1	0.1	(0.0)
Дуудлага худалдаа	-		-
Байгалийн нөөц ашигласны телбер	77.9	122.7	(44.8)
Ан амьтны нөөц ашигласны телбер			-
Ус, рашааны нөөц ашигласны телбер	1.6	1.0	0.6
Ан амьтны нөөц ашигласны телбөр	73.3	118.7	(45.4)
Байгалийн ургамлын нөөц ашигласны телбер	3.0	3.0	-
Татварын бус орлого	1.0	0.7	0.3
Нийтлэг татварын бус орлого	1.0	0.7	0.3
Хувьцааны ногдол ашиг			-
Торгуулийн орлого	1.0	0.7	0.3

Нийт орлого 201.1 сая төгрөгөөр биелж 64.4 сая төгрөгөөр давсан байна. Орлого давсан шалтгаан нь ан амьтны нөөц ашигласны телбөр 45.4 сая төгрөгөөр давсан нь гол нөлөө үзүүлсэн байна. Орлогыг нэр төрлөөр авч үзвэр хувь хүний орлогын албан татвар 11.2, хөрөнгийн албан татварын орлого 5.1, улсын тэмдэгтийн хураамж 26.0 сая төгрөгөөр тус тус давж түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны телбөр 6.9, хог хаягдлын үйлчилгээний хураамж 15.7, ус рашааны нөөц ашигласны телбөр 0.6, торгуулийн орлого 0.3 сая төгрөгөөр тус тус тасалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар ЭМДС-аас Ковид-19 цар тахлын илүү цаг урамшуулал, эмийн зардалд 25.0, онцгой байдлын газар, статистикийн хэлтэс, ЭМГ-аас 37.8, хүүхэд хамгаалах багийн санхүүжилт 0.3, усны хөнгөлөлтийн 12.9, аймгийн ОНХС-ын эрх шилжиж ирсэн 46.7 сая төгрөг нийт 122.7 сая төгрөгийн орлого бүрдүүлэн 122.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Эрдэнэбүрэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай дараах асуудлууд байна. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сангаас 2011-2021 онуудад олгосон 49 зээлдэгчийн 336.6 сая төгрөгийн зээл олгогдсоноос 13 зээлдэгч зээл бүрэн төлж дууссан, 11 иргэний 76.5 сая төгрөгийн зээлийн төлөх хугацаа болоогүй, 25 иргэний 87.7 сая төгрөгийн мянган төгрөгийн зээлийн авлага нь хугацаа хэтэрч байгаа нь сангийн хөрөнгийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд хашааны үнэ болох 9.5 сая төгрөг төвлөрснийг иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй, ИТХ-аар хэлэлцэж батлаагүй арга хэмжээнд зарцуулсан нь ОНХС-ын журмыг зөрчсөн байна.
3. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэхтэй холбоотой ОНХС-ын төлөвлөгөөнд 8.6 сая төгрөг төлөвлөж зарцуулсан байна. Тайланд хугацаанд 189 хүн Ковид-19 цар тахлаар өвчилж 10.2 сая төгрөгийн нэг удаагийн эм, эмнэлгийн хэрэгсэл урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан байна.
4. ОНХС-ын 6.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Хар-Ус ОНӨААТҮГ байгуулсан боловч ямар ажил үүрэг гүйцэтгэсэн нь тодорхойгүй, зарцуулалтын анхан шатны баримт байхгүй, санхүүгийн тайлан гаргаж нэгтгүүлээгүй зөрчил илэрлээ.

3.8 Аудитын гол асуудал

Эрдэнэбүрэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд сумын ОНХС-аар 31.8 сая төгрөгийн барилга байгууламж, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар эмнэлгийн тээврийн хэрэгсэл 38.3, бусад эх үүсвэрүүдээс ирсэн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэсэн асуудал нь санхүүгийн тайланд нөлөө үзүүлсэн байна.

Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасан заалтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 157 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн байна. Аймгийн хэмжээнд сум хөгжүүлэх сангийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг мэдээлэх тусгай цэсгүйгээс тайлант онд орсон орлогын гүйлгээг мэдээлээгүй, зарлагын гүйлгээ гаргаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага, 27.8 сая төгрөгийн 4 зөвлөмж өгөгдсөн бөгөөд албан шаардлага бүрэн биелж, зөвлөмжийн хэрэгжилт 70 хувьтай хэрэгжүүлсэн байна. ОНХС, СХС-тай холбоотой өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Ковид-19 цар тахлын гаргасан зардлын зарцуулалт, Хар-Ус ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүнг авч үзэх нь зүйтэй байна.

3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 5 тайланг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-1 (сумын 12 жилийн сургууль), “Хязгаарлалттай” 2 (ЭМТөв, сумын хүүхдийн цэцэрлэг) нийт 3 дүгнэлт гаргасан байна.

Эрдэнэбүрэн сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 157.2 сая төгрөгийн 20 алдаа зөрчил илэрч, 12.8 сая төгрөгийн 10 алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 144.4 сая төгрөгийн алдаа зөрчлөөс 6.1 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 төлбөрийн акт тогтоон, 31.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах 2 албан шаардлага өгч, 107.0 сая төгрөгийн 6 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5. Аудитад хамрагдсан байгууллагын судалгаа /сая.төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Эрдэнэбүрэн сумын ЕБС	8	100.0	5	9.6	1	5.5	0	0	2	84.9
2	Эрдэнэбүрэн сумын хүүхдийн цэцэрлэг	7	21.8	4	3.2	0	0	1	0	2	18.6
3	Зэрэг ЭМТ	5	35.4	1	0	1	0.6	1	31.3	2	3.5
Дүн		20	157.2	10	12.8	2	6.1	2	31.3	6	107.0

[Эх сурвалж](#): Эрдэнэбүрэн сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

4. Нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 317.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 42.0 сая төгрөгийн алдааг 3 алдааг залруулж, 104.9 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өгч, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 170.1 сая төгрөгийн 8 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. ЗДТГ нь Шилэн дансны цахим системд оруулбал зохих мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв, бүрэн мэдээлээгүй Үүнд: 1. Төсвийн гүйцэтгэлийн тайлан 1,2 дугаар сар тухайн сарын батлагдсан төсөв, хэтрэлт, хэмнэлт мэдээлээгүй бусад саруудын тайлбар мөн мэдээлээгүй, 2. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ дутуу, зарлагын мөнгөн гүйлгээ, 3. санхүүгийн тайлан хагас жилээр мэдээлэх хэсэгт төсвийн хэлбэлзлийн тайлан хавсаргасныг мэдээлсэнд тооцохгүй, 2020 оны санхүүгийн тайлангийн бүтэн жилийг мэдээлэх хэсэгт мэдээлээгүй, 4. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт мэдээлээгүй, 5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээг дутуу мэдээлсэн байсныг нөхөж мэдээлсэн.
2. Ажилтан албан хаагчдын хувийн унаанд шатахуун олгож албан хэрэгцээнд зарцуулдаг болон Засаг даргын ХОА 99-02 дугаарын TOYOTO маркийн LAND 105 авто машинд шатахуун олгосон нь явсан ажлын тайланг хавсаргаж оруулаагүй, жолоочийн тооцоог үнэн зөв бодож хянаагүй, жолоочийн замын хуудас дутуу байхгүй, шатахуун авч явсан албан тушаалтны гарын үсэг байхгүй зэрэг 12.8 сая төгрөгийн алдааг залруулсан.
3. Аймгийн ИТХ-ын 77 дугаар тогтоолоор УАЗ маркийн фермер автомашиныг дуудлага худалдаагаар худалдан борлогдсоныг тээврийн хэрэгслээс хасаж бүртгэв. Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 4,900.000 төгрөгийн үнэ бүхий угсардаг малын хашааг үнэ төлбөргүй хүлээлгэн өгснийг орлого авч залрууллаа. Мөн Доромын худаг дээр хийсэн 1,800.000 төгрөгийн засвар үйлчилгээг капиталжуулж, 990,000 төгрөгийн ус цэвэршүүлэгчийг орлого авч, 1,540.000 төгрөгийн худгийн насосуудыг ангилан бүртгэж нийт 29.2 сая төгрөгийн алдааг тус тус залрууллаа.
Шийдвэрлэсэн нь: Эрдэнэбүрэн сумын ЗДТГ-ын даргын 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 1/83 тоот албан бичгээр ирсэн хүсэлтийг үндэслэж залруулга хийгдлээ.

4.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Сум хөгжүүлэх сангаас 2011-2017 онуудад зээл авсан 25 зээлдэгч 87.7 сая төгрөгийн зээл авсан бөгөөд одоог хүртэл төлөөгүй, хугацаа хэтрүүлэн төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулсаар байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 5.4-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" заалтууд болон сум хөгжүүлэх сангаас олгох барьцаат зээлийн гэрээний 6.2.2. "Гэрээний 3.1-т заасан хугацаанд сар бүрийн төлбөрийн хуваарийн дагуу зээлийн төлбөрийг зээлдүүлэгчийн 100161600055401 тоот дансанд төлөх", 6.2.3. "Гэрээнд өөрөөр заагаагүй бол зээлийн төлбөрийн гэрээний 3.1-д заасан хугацаанд төлж барагдуулаагүй тохиолдолд төлбөрийн хуваарь зөрчигдсөн өдрөөс эхлэн төлөгдөөгүй байгаа зээлд үндсэн хүү /үндсэн хугацааны болон хэтэрсэн хугацааны /-ний хамт нэмэгдүүлсэн хүүг хэмж тооцож төлөх", 10.2-д "Хэрэв талууд гэрээний 10.1 дэх хэсэгт заасан аргаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

Илрүүлэлт 2: Соёлын төвийн захирал ур чадварын нэмэгдэл 2021 оны эхний 2 сар 40 хувь, дараагийн саруудад 25 хувиар бүтэн жил, батлагдаагүй орон тоонд бүжгийн багш бичиг хэргийн ажил, үйлчлэгч нярвын ажлыг тус тус хавсран гүйцэтгэж 15 хувийн нэмэгдэл авсан 3.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн "6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", "16.5.9. дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1. "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй

шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.2. "Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаалтан бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах тухай албан шаардлага өгөв.

Илрүүлэлт 3: ОНХС-гийн дансанд орсон хашааны 9.5 сая төгрөгийн орлогоос иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй, төсөв төлөвлөгөөнд батлагдаагүй номын үнэ, хашааны нөхөн төлбөр, ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулахад 9.5, ОНХС-ийн 4.2.5 дахь заалтыг зөрчиж цагдаагийн кабоны засварт 1.5, цаг уурын хашааны зардалд 3.0, нийт 14 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60.3.6. "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ", ОНХС-ийн 4.2.5. "Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн зардал"; гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах тухай албан шаардлага өгөв.

4.4. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 Төсвийн гүйцэтгэл, төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын төсөвт байгууллагын дүнгээр тогтмол зардлыг 206.5 сая төгрөгөөр төлөвлөж, төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан байна. Төрийн сангийн зарлагын хуулгаар 195.2 сая төгрөгийн зардал гаргаж 11.4 сая төгрөгийг бусад бараа үйлчилгээний зардалд гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7-д "энэ хуулийн 22.2-т заасан төсвийн ангиллын төрөл бүрээр дэлгэрэнгүй ангилал тогтоох, түүнийг төсвийн төлөвлөлт, тайлагналт, гүйцэтгэлд ашиглах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно", 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг мөрдөн ажиллах заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Эдийн засгийн ангиллын дагуу төсөвт журмын дагуу зохицуулалт хийж зардлыг санхүүжүүлэн, Төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв илэрхийлж тайлагнах

4.4.2 Бараа материалын зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: ЗДТГ нь бараа материалыг зарлагадахдаа нярав нь албан хаагчдаар шаардах хуудас бүрэн бичүүлж дарга, нягтлан бодогчоор хянуулж зөвшөөрсөн тохиолдолд олгож хэвших, мөн эд хариуцагчийн карттай тулган үндсэн хөрөнгийн биет тооллого хийгээгүй, шаардах хуудас бичсэн албан хаагчийн гарын үсэггүй, тоо ширхгээр тулгалт хийж баталгаажуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөн ажиллах, цаашид үлдэгдлийг баталгаажуулж баримтжуулж, хяналт тавин үнэн зөв бодитой тооллого хийх.

4.4.3 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ЗДТГ нь Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, төсвийг үр ашиггүй үрэлгэн зарцуулсан байна. Мөн батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалт, Засгийн газрын тогтоол шийдвэрийг мөрдөн ажиллаж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

4.4.4 И баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: ЗДТГ нь И баримт болон анхан шатны баримт дутуу ажил гүйлгээг санхүүжүүлсэн байна. Үүнд: Хувь хүний орлогын албан татварын 10 хувийг суутгаж ногдуулаагүй, Тусгай зөвшөөрөл бүхий ААНэгжээс эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан аваагүй, түлээ нүүрс, шатахуун, бэлэг дурсгалын зүйлс, бараа материалыг анхан шатны баримтын бүрдэлгүй бэлтгэж тайлагнасан.

Өгсөн зөвлөмж: Сумын төрийн сангаас зардлыг санхүүжүүлэхдээ и баримтаар баталгаагүй ажил гүйлгээг гаргахгүй байх.

4.4.5 Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ИТХ-ын нарийн бичгийн дарга 2021 оны 9 дүгээр сард тэтгэвэрт гарсан байхад тухайн ажилтны урд авч байсан цалин хөлсийг хэвээр тогтоож олгосон байна.

Өгсөн зөвлөмж: Тухайн ажилтныг зайлшгүй ажиллуулах шаардлагатай бол хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулах талаарх Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн чиглэлийг баримталж ажиллах.

3.4.6 Цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын ИТХ нь 2021 оны цалингийн сангийн хэмнэлтийг үр дүнгийн урамшуулал хэлбэрээр шийдвэр гаргаж зарцуулсан байгаа нь Засгийн газрын 43 дугаар тогтоолтой нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалт, Засгийн газрын тогтоол шийдвэрийг мөрдөн ажиллаж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.4.7 Шатахууны зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Соёлын төв нь тайлант онд батлагдсан шатахууны зардлаас илүү шатахууныг бусад зардлуудаас гүйлгэн зарцуулсан байна.

Зөвлөмж: Илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалыг мөрдөн ажиллах.

3.4.8 Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Соёлын төвийн санхүүгийн тайлан баталгаажуулах явцад бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудаас авсан өр, авлагын судалгаагаар 0.7 сая төгрөгийн өртэй мэдээлэл ирүүлснийг хянахад хувь хүний өр байгууллага дээр бичигдсэн зөрчил илэрсэн.

Өгсөн зөвлөмж: Тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажсан өр төлбөрийг хариуцагчаар төлж барагдуулах арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 3-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Хүснэгт 5. Аудитад хамрагдсан байгууллагын зөрчлийн судалгаа

/сая.төгрөг/

д/д	байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗахирагч	1	11.4			-	-	-	-	1	11.4
2	Зэрэг ЗДТГ	6	195.6	3	42	-	-	-	-	3	153.6
3	Зэрэг ИТХ	2	3.8			-	-			2	3.8
4	Зэрэг Соёлын төв	3	4.5	-	-			1	3.2	2	1.3
5	Зэрэг ОНХС	1	14.0					1	14	-	-
6	Зэрэг СХС	1	87.7					1	87.7		
Дүн		14	317.0	3	42	-	-	3	104.9	8	170.1

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

Ц.АЗЗАЯА